



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	12
3.1	Цалин урамшуулалтай холбоотой асуудал.....	12
3.2	Сургалтын зардалтай холбоотой асуудал.....	13
3.3	Тайлагнал, тайлантай холбоотой асуудлаар	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Хавсралт.....	21
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 01/597
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Е.ОЮУНБИЛЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Гадаадын иргэн харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин, урамшуулал, бусад зардал, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн харьяатын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 7-ноос 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Аудитор С.Отгонхорлоо, Гэрээт аудитор Ш.Гүрпүрэв нар гүйцэтгэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 01/404 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.



Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гадаадын иргэн, харьяатын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Байгууллагын эрхэм зорилго нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллагын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд явуулахад оршино. Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар удирдлагын манлайллыг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх
- Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой, цомхон, чадварлаг бүтцийг бий болгох, хөгжүүлэх
- Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих нөхцөлийн талаарх олон улсын болон хоёр талт гэрээний хэрэгжилтийг хангах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:



- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаадын иргэн, харьяатын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “UNICUS” програм хангамж ашигладаг байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь 7 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 525.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гадаадын иргэн, харьяатын газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.



Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,637.0 сая төгрөгийн 1 хувь буюу 46.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөн тогтоосон ба төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тогтоосонтой холбоотой болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 7 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Үүнээс: Гэрээгээр хийлгэсэн	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5		2		
	Дүн	5		2		

Аудитаар 5 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 905.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.3 хувь буюу 2.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84.9 хувь буюу 769.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 14.8 хувь буюу 133.8 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.



Аудитаар орон нутгийн төсвийн шууд захирагчийн хэмжээнд 0.4 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	16	62.5	2	0.5	6	34.1	8	27.9				
2	ТТЗ	7	843.0	1	2.1	2	735.0	4	105.9				
	Дүн	23	905.5	3	2.6	8	769.1	12	133.8				

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээний 5 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаснаас материаллаг хэмжээний, анхаарал татахуйц алдаа, зөрчил илрээгүй байна. Аудитаар нийт 62.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх 2 төлбөрийн акт, 34.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 6 албан шаардлага, 27.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн шууд захирагчийн болон Буянт-Ухаа дахь ГИХГ-ын санхүүгийн тайланг, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамруулсан бөгөөд аудитаар нийт 843.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2.1 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 735.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 105.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлээ.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.



Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Дотоод томилолтын талаар

Тайлант онд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд албан томилолтоор ажилласан албан тушаалтанд аймагт ажиллах томилолтын зардлаар тооцож, томилолтын мөнгийг илүү олгосон, мөн томилолтын хоногийг илүү бодож олгосон зэргээр нийт 2.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоох

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар

Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Замын-Үүд сумын Гадаадын иргэн харьяатын газар нь Замын-Үүд сумын Засаг даргын 2017 оны А/378, А377, А/41, А/327 тоот захирамжуудаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд 288.5 сая төгрөгийн үнэ бүхий 8 ширхэг автомашин, 2018 онд 198.0 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг Ландкрузер-200 автомашиныг тус тус худалдан авч Гадаадын иргэн харьяатын газар буюу төв байгууллагадаа шилжүүлсэн байна. Уг автомашинуудыг худалдаж авах, бүртгэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, 5 автомашиныг харьяа газруудад хуваарилсан байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлэх

Асуудал 3: Урьдчилж гарсан зардлын талаар

2018 онд АРР системийг нэвтрүүлэх програм, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулан програм тоног төхөөрөмжийн төлбөр 248.5 сая төгрөгийг 100 хувь шилжүүлсэн байна. Уг програм тоног төхөөрөмжийг 2019 оны 1 сарын 10-нд хүлээн авсан тухай акт үйлдсэн боловч өнөөг хүртэл бүртгэлд тусгаж аваагүй байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлэх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц чухал асуудал илрээгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Гадаадын иргэн, харьяатын газрын төсөвт 1 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 6,585.3 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 6,561.3 сая



төгрөгийг улсын төсвөөс, 24.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагааны орлого 7,801.9 сая төгрөгийг дүүргийн татварын орлогод төвлөрүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлого 24.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 23.7 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Зардлын нийт гүйцэтгэл 6,354.7 сая төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин НДШ 145.7 сая төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 35.2 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 4.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 30.4 сая төгрөгийг тус тус хэмнэн ажилласан байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлогоос 8.1 сая төгрөгийг Сангийн сайдын 2018 оны 275 дугаар тушаалын дагуу зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Гадаадын иргэн, харьяатын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, бусад мэдээллийг байрлуулсан ба шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар 979 мэдээллийг олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2018 оны бүтэн жилийн байдлаар нийт 991 мэдээллийг мэдээлэх бөгөөд хэрэгжилт дунджаар 98.7 хувьтай байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Гадаадын иргэн, харьяатын газрын нэгтгэсэн тайланд 3 зөвлөмж, харьяа бүсүүдэд 9 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаадын иргэн харьяатын газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил



гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаадын иргэн, харьяатын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Цалин урамшуулалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын дотоод журамд жилийн эцсийн ажлыг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох хувь хэмжээг тодорхой тусгаагүйгээс тайлант жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас 70.0-80.0 хувиар тооцож, хавтгайруулан олгож нийт 54.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн ур чадварын нэмэгдлийг сар бүр 25 хувиар 76 хүнд хавтгайруулан жилийн дүнгээр 48.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад ". . . төрийн албан хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно. Албан хаагчийг тийнхүү шагнаж урамшуулах үзүүлэлт, журмыг төрийн тухайн байгууллага боловсруулж хэрэгжүүлнэ" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Баллагдсан төсөв хэтрэх, холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:



Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

3.2 Сургалтын зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 онд тус байгууллагын даргын А/453 тушаалаар англи хэлний сургалтанд 5, А/115 тушаалаар нярав, компьютерын хавсарсан сургалтанд 1, нийт 6 ажилтанг мэргэжлийн бус сургалтуудад хамруулан нийт 3.2 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

3.3 Тайлагнал, тайлантай холбоотой асуудлаар

3.3.1 Илрүүлэлт

а. Байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг бүртгэж тайлагнах талаар нэгдсэн бодлого арга зүйгээр хангаж ажиллаагүйгээс ГИХГ-ын харьяа байгууллагуудын зарим нь мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн тайланд тусгасан, зарим нь зөвхөн үр дүнгийн тайлан тусгасан, зарим нь аль ч тайланд тусгаагүй зэргээс шалтгаалан ГИХГ-ын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан дахь үйл ажиллагааны орлого буруу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх" Санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

б. Төвлөрүүлэн захирагчийн тайланг Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан маягтаар гаргаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 341 дүгээр тушаалын 1-д заасныг мөрдөж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:



Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх. Холбогдох журам зөрчигдөх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг бүртгэж тайлагнах талаар нэгдсэн бодлого арга зүйгээр хангаж ажиллах. Санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан маягтаар гаргах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

